



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/52/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,695.7	10,152.3	8,456.6
Бараа материал	99,899.4	114,136.9	14,237.5
Үндсэн хөрөнгө	2,701,062.0	3,058,268.1	357,206.1
Нийт хөрөнгө	2,802,657.0	3,182,557.4	379,900.4
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,802,657.0	3,182,557.4	379,900.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,802,657.0	3,182,557.4	379,900.4

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,975.5 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, төлбөр барагдуулах 4 акт тогтоож, зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага өгч, зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байсан С.Мөнх-Аюуш нь эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Түүнд Түнэл сумын ЗДТГ-ын даргын тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 дэх заалтыг үндэслэн 5,168.9 төгрөгийн тэтгэмж олгосон байна. Гэвч ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй талаар эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр байхгүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.3 дахь "ажилтан эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд түүнийг шилжүүлэн ажиллуулах өөр ажлын байр байхгүй, энэ хуулийн 144.1-д заасан арга хэмжээг ажил олгогч авсан боловч ажилтан хөдөлмөр эрхлэх боломжгүй бол" заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

2. Түнэл сумын ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр ажилчдад жигдэрсэн биеийн тамирын хувцас худалдан авч 4,751.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1 дэх заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллагын төсвөөс Анар принт ХХК-д 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас өөр бараа, материалыг худалдаж авсан ба бараа материалын орлого, зарлагын баримтуудыг хуурамчаар үйлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай тус тус нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

4. Түнэл сумын ЗДТГ-ын Хоршоо хөгжүүлэх сангийн мэргэжилтэнд томилолтын мөнгө олгохдоо 756.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай тус

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тус нийцээгүй ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Тус байгууллага нь тайланд онд 4 удаагийн гүйлгээгээр нийт 1,814.6 мянган төгрөгийг Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна. Мөн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь “аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын засаг даргын орлогч Улаанбаатар хотод албан бус ажлаар ажилласан боловч 485.0 мянган төгрөгийн албан томилолтын мөнгө олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 16.5.4 дэх “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийг үр ашигтай удирдаж ажиллах

Илрүүлэлт: Байгууллагын төсвөөс Түнэл-Эг ойн ангид 1,500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хууль-ийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн хөрөнгөөр хандив, тусламж өгөхгүй байх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хуулийн үндэслэлгүй тэтгэмж олгосон	1	5,168.9	1	5,168.9								
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж биелүүлээгүй	1	1,814.6			1	1,814.6						
Томилолтын мөнгө илүү олгосон	1	1,241.0	1	756.0			1	485.0				
Төсвийн хөрөнгөөр хандив өгсөн	1	1,500.0					1	1,500.0				
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	1,500.0	1	1,500.0								
Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн	1	4,751.0	1	4,751.0								
Дүн	7	15,975.5	4	12,175.9	1	1,814.6	2	1,985.0				



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/88
танай _____-ны № _____-Т

ТҮНЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ЧИМЭДМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Түнэл сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. **Үүнд:**

- Тус байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байсан С.Мөнх-Аюуш нь эрүүл мэндийн шалтгааны улмаас өөрийн хүсэлтийг өгч ажлаас чөлөөлөгдсөн байна. Түүнд Түнэл сумын ЗДТГ-ын даргын тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 дэх заалтыг үндэслэн 5,168.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна. Гэвч ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй талаар эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр байхгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.3 дахь "ажилтан эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд түүнийг шилжүүлэн ажиллуулах өөр ажлын байр байхгүй, энэ хуулийн 144.1-д заасан арга хэмжээг ажил олгогч авсан боловч ажилтан хөдөлмөр эрхлэх боломжгүй бол" заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Түнэл сумын ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр ажилчдад жигдэрсэн биеийн тамирын хувцас худалдан авч 4,751.0 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1 дэх заалттай нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тус байгууллагын төсвөөс Анар принт ХХК-д 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас өөр бараа, материалыг худалдаж авсан ба бараа материалын орлого, зарлагын баримтуудыг хуурамчаар үйлдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны

6724040179

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай тус тус нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Түнэл сумын ЗДТГ-ын Хоршоо хөгжүүлэх сангийн мэргэжилтэнд томилолтын мөнгө олгоходоо 756.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай тус тус нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүдийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 1,679.9 мянган төгрөгөөр давсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 379,900.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайланд онд 4 удаагийн гүйлгээгээр нийт 1,814.6 мянган төгрөгийг Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Түнэл сумын ЗДТГ-ын нягтлан бодогчоор 2023 онд 3 өөр хүн солигдож ажилласан байна. Нягтлан бодогчийн албан тушаалд тогтвор суурьшилтай ажиллах хүнгүй байгаа нь байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР